

Энгийнээс аравт руу

N нь хүртвэр, D нь хуваарь байх N/D хэлбэртэй энгийн бутархай тоог аравтын бутархай руу хөрвүүлэх програм бич. Хэрвээ аравтын бутархай нь цифрүүдийн дарааллыг давтдаг бол уг дарааллыг хаалтанд хийнэ үү. Жишээ нь $1/3=0.3333333333\dots$ үүнийг 0.(3) гэж харуулна мөн $41/333=0/123123123\dots$ энэ тоог 0.(123) гэх мэт. Бүхэл тоог xxx.0 гэсэн хэлбэрээр харуул. Жишээ хөрвүүлэлтүүд:

$$1/3 = 0.(3)$$

$$22/5 = 4.4$$

$$1/7 = 0.(142857)$$

$$2/2 = 1.0$$

$$3/8 = 0.375$$

$$45/56 = 0.803(571428)$$

Програмын Нэр: fracdec

Оролтын Формат

Нэг мөрөнд зайгаар тусгаарлагдсан хоёр бүхэл тоо N, D ($1 \leq N, D \leq 100000$.) байна.

Жишээ Оролт (файл fracdec.in)

45 56

Гаралтын Формат

Дээр заасны дагуу аравтын бутархай руу хөрвүүлж харуул. Хэрвээ үр дүн 76-гаас олон тэмдэгт болвол мөр бүрт 76 тэмдэгтээр хэвлэ.

Жишээ гаралт (файл fracdec.out)

0.803(571428)

Орчуулсан Б.Даваабаяр